

**УИХ -ЫН ХЯНАЛТ ШАЛГАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСГҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ**

*Б. Мөнхцэцэг, Ө. Мөнхтунгалаг, Д. Жигваагүнсэл  
Б. Ариунжаргал, Д. Золбоо*

**АГУУЛГА****ТАНИЛЦУУЛГА**

- 1. 1996-2000 оны хугацаанд УИХ-аас хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн нэгдсэн дүн**
  - 1.1. НЭГДСЭН ТОЙМ
  - 1.2. СУДАЛГААНЫ ДҮН

**ДҮГНЭЛТ****АШИГЛАСАН МАТЕРИАЛ****ХАВСРАЛТ**

Хавсралт - 1

- Улсын Их Хурлын даргын захирамжаар хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996-2008 он

Хавсралт - 2

- Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээ 1996 - 2009 он

Хавсралт-3

- Улсын Их Хурлын Байгаль орчин Хүнс Хөдөө Аж Ахуйн Байнгын Хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996 - 2008 он

Хавсралт - 4

- Улсын Их Хурлын Нийгмийн Бодлогын Байнгын Хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996 - 2008 он

Хавсралт - 5

- Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996-2007он

Хавсралт - 6

- Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996 - 2008 он

• Хавсралт - 7

- Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996 - 2008 он

Хавсралт - 8

- Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996-2008 он

Хавсралт - 9

- УИХ-аас 1992-2008 он дуусталх хугацаанд УИХ-ын тогтоолоор хийсэн хяналт шалгалтын ажлын хэсгийн нэгтгэл

\* \* \*

## ТАНИЛЦУУЛГА

Судалгаа мэдээллийн зорилго нь УИХ -ын гишүүн Х.Тэмүүжингийн 2009.10.19-ний өдрийн 11/6723 тоот албан бичгээр ирүүлсэн УИХ-аас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор нийт хичнээн ажлын хэсгийг хэдийд хэрхэн байгуулан ажиллуулж байсан тэдгээр ажлын хэсгийг байгуулах хууль зүйн үндэслэл, зохицуулалт нь юу байгаа, түүнчлэн тухайн үед байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан ажлын хэсгүүдийн ажлын үр дүн, шийдвэрүүдийн талаархи товч мэдээлэл бэлтгэх захиалгын дагуу судалгааны төвийн судлаач Б.Мөнхцэцэг, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Д.Золбоо, Б.Ариунжаргал нар 2009 оны 10-р сарын 20-ноос 11 дүгээр сарын 5 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв. Мөн УИХ-ын хяналт, шалгалтын ажлын хэсгүүдийн шалгалтын дүнг хэлэлцсэн байдал, гаргасан шийдвэрийн биелэлтийг холбогдох Байнгын хороодоос гаргуулж авсан болно.

**Судалгааны мэдээллийн эх сурвалжийг бүрдүүлсэн байдал:** Судалгаа мэдээллийг хяналт, шалгалтын хэлтсийн жилийн тайланд тусгасан статистик мэдээлэл, Байнгын хороодын тогтоол, хуралдааны тэмдэглэл, ажлын хэсгүүдийн ажлын тайлан болон архивын нэгжүүдийг нэг бүрчлэн түүвэрлэн, хэрэгжилтийн талаарх мэдээллийг олдоцын хэрээр ашиглав.

**Судалгааны арга зүй:** 1996 - 2009 онуудын УИХ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, Байнгын хороодын тогтоол, УИХ -ын Тамгын газрын Хяналт шалгалтын хэлтсийн ажлын тайлан, хуралдааны тэмдэглэлүүдээс хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн тогтоол, үр дүнгийн талаархи материалуудыг шүүн статистик мэдээлэл бэлтгэж нэгтгэн дүгнэв.

Хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны үр дүнг нэгтгэх, статистик мэдээлэл бэлтгэх явцад гарсан бэрхшээл, хүндрэлтэй асуудлууд:

- Зарим хяналт шалгалтын ажлын хэсэг илтгэх хуудас болон тайлангаа харъяалагдах Байнгын хороонд өгсөн эсэх нь тодорхойгүй
- УИХ -ын Тамгын газрын Хяналт шалгалтын хэлтэс тус ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны талаарх статистик мэдээг гаргахдаа УИХ-ын тогтоол болон УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн ажлын явц, шалгалтын үр дүнгийн биелэлтэнд анхаарч Байнгын хороодын тогтоолоор байгуулагдсан Хяналт шалгалтын ажлын хэсгийн шалгалтын үр дүнг төдийлөн анхаараагүй, дэлгэрэнгүй статистик бүртгэл мэдээлэл байгаагүй нь тухайн ажлын хэсгийг байгуулахдаа Тамгын газраас шийдвэрийн биелэлтийг хариуцсан хяналт тавих ажилтанг томилдоггүй, хариуцах эзэн тодорхойгүй
- Зарим Байнгын хороодын тогтоол, хуралдааны тэмдэглэл нь архивт өгөгдөөгүй, орхигдсон, архивын хавтаст оруулах материалын иж бүрдэл дутуу
- Хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн тайлан мэдээг Байнгын хороод нэгтгэх үү, хяналт шалгалт хариуцсан ажилтан хариуцах уу гэдэг нь тодорхойгүй, ажлын хэсгүүдийн ажлын үр дүнд хяналт тавих эрх бүхий субъект түүний эрх үүрэг тодорхой бус зэрэг асуудлууд байгаа нь харагдаж байна.

**УИХ -ын хянан шалгах чиг үүргийн эрх зүйн үндэслэл:** УИХ-ын хянан шалгах үйл ажиллагаа нь УИХ-ын тухай хууль, УИХ-ын хуралдааны дэгийн тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн холбогдох зүйл заалтуудад үндэслэн УИХ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, Байнгын хорооны тогтоолоор ажлын хэсэг

байгуулах журмаар хэрэгжиж байгаа бөгөөд хяналт шалгалт болон судлан танилцах ажлын чиглэлээр ажлын хэсгүүд ажиллаж, хууль тогтоомжийн хэрэгжилт, зарим тодорхой асуудлаар шалгалт хийж иржээ.

\*\*\*

## 1. 1996 - 2009 оны хугацаанд УИХ -аас хяналт, шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн нэгдсэн дүн /мэдээлэл/

### 1.1. Нэгдсэн тойм

УИХ -ын 1996 - 2009 оны ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр

- УИХ -ын даргын захирамжаар 31
- УИХ -ын тогтоолоор 2
- Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 28
- Эдийн засгийн байнгын хороо 38
- Төрийн байгуулалтын байнгын хороо 30
- Хууль зүйн байнгын хороо 21
- Нийгмийн бодлогын байнгын хороо 25
- Байгаль орчин, Хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо 46
- Төсвийн байнгын хороо 26

... ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллажээ. (График – 1.1.)




График – 1.1.

### Тайлбар:

УИХ -ын 1996 - 2009 он хүртэлх ээлжит чуулганы хугацаанд хяналтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгүүд (УИХТГ -ын СШОНХТ 2009)

\*\*\*

Энэ хугацаанд байгуулагдан ажилласан хяналт шалгалтын ажлын хэсгийг Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээгээр нь авч үзвэл Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо харьцангуй ачаалалтай ажилласан үзүүлэлт харагдаж байна.

**1.2. Судалгааны үр дүн:**

Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн ажлын үр дүнг хэлэлцсэн байдлыг Хүснэгт 1.2.1-д гаргасан үзүүлэлтээс авч үзэхэд нийт байгуулагдсан 244 ажлын хэсгийн шалгалтын дүнг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 21 удаа, холбогдох байнгын хороодоор 125 удаа /Давхардсан тоогоор/ ямар нэг байдлаар хэлэлцэж УИХ-ын 7 тогтоол, байнгын хорооноос 62 тогтоол гарган биелэлтэнд нь хяналт тавьж ажиллажээ. Үүнээс гадна хяналтын чиглэлээр байгуулагдсан боловч ажлын хэсэг ажилласан эсэх нь тодорхойгүй 60, огт ажиллагаагүй 14 ажлын хэсэг тус тус байна.

**Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн нэгдсэн дүн**

/УИХ-ын чуулганы бүрэн эрхийн хугацаагаар/

**Хүснэгт -1.2.1.**

Хугацаа		Байгуулагдсан хяналт шалгалтын ажлын хэсгийн тоо				Гаргасан тогтоол шийдвэрийн тоо		Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал			
		УИХ-ын тогтоолоор	УИХ-ын даргын захирамжаар	Байнгын хорооны тогтоолоор	Бүгд	УИХ-ын	Байнгын хорооны	УИХ-ын нэгдсэн хуралдаанаар	Байнгын болон дэд хорооны хуралдаанаар	Ажлын хэсэг ажилаагүй	Ажлын хэсэг ажилласан эсэх нь тодорхойгүй
II дахь удаагийн чуулган	1996-2000	2	7	77	86	2	12	4	40	10	14
III дахь удаагийн чуулган	2000-2004	-	9	58	67	2	10	6	17	2	21
IV дахь удаагийн чуулган	2004-2008	-	13	55	68	0	22	23	40	2	25
V дахь удаагийн чуулган	2009 онд	-	2	21	23	3	18	9	28	0	0
Дүн		2	31	211	244	7	62	21	125	14	60

**Тайлбар:**

УИХ -ын чуулганы бүрэн эрхийн хугацаагаар авч дүгнэлээ. УИХТГ -ын СШОНХТ 2009

\* \* \*



УИХ -ын чуулганы бүрэн эрхийн хугацаанд хяналт, шалгалтын ажлын хэсэг байгуулагдан ажилласан байдлыг авч үзвэл: /График-1.2.1./




График-1.2.1.

\*\*\*

1996-2009 оны хугацаанд хийгдсэн хяналт, шалгалтын ажлын хэсгийн үр дүнг хэлэлцсэн байдлыг авч үзвэл: /График-1.2.2./




График-1.2.2.

\*\*\*

1996 - 2009 оны хугацаанд ажилаагүй, ажилласан эсэх нь тодорхойгүй ажлын хэсгийн тоог авч үзвэл: /График-1.2.3./



График-1.2.3.

\*\*\*

**Дүгнэлт**

УИХ-ын 1996-2009 оны чуулганы хугацаанд УИХ-ын даргын захирамж, УИХ-ын тогтоол болон Байнгын хорооны тогтоолоор нийт 244 ажлын хэсэг байгуулагдан ажиллажээ. Шалгалтын дүнг хэлэлцэж шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл нийт байгуулагдсан ажлын хэсгийн 70 орчим хувь нь ямар нэгэн байдлаар хэлэлцэгдэн шийдвэрлэгдсэн байна.

Үүнд:

- УИХ-ын тогтоол гарсан
- Байнгын хорооны тогтоол гарсан
- Байнгын хороогоор хэлэлцэж протоколд тэмдэглэсэн
- Засгийн газарт санал хүргүүлсэн
- Харьяа яамны сайдад үүрэг өгсөн
- Байнгын хороонд шалгалтын дүнг илтгэх хуудсаар танилцуулсан
- Холбогдох газарт албан тоот явуулсан зэрэг болно.

Мөн хяналт шалгалт явуулж буй асуудлын онцлогоос хамаарч шалгалтыг хойшлуулах, ажлын хэсгийн хүсэлтээр хугацааг сунгах, дахин мэргэжлийн шинжээч оролцуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний зөвлөмж хүргүүлэх гэх мэтчилэн шийдвэрлэж иржээ. Үлдсэн 30 хувь нь ажиллаагүй болон ажилласан эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь дараах хүчин зүйлээс шалтгаалж байна.

Үүнд:

- УИХ-ын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөгдсөн
- УИХ-ын чуулганы бүрэн эрхийн хугацаа дамжсан
- Байнгын хорооны хурлаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн
- Ажлын хэсэг шалгалтын ажлын онцлогоос хамаарч дахин шинээр зохион байгуулагдсан
- Шалгалтын ажлын мэдээлэл нууцын зэрэглэлд хамаарсан
- Ажлын хэсэг ажилдаа хайнга хандсан
- Хяналт, шалгалтын ажлын үр дүнг үнэлэх нэгдсэн нэг ойлголт, шалгуур үзүүлэлт байхгүй зэрэг болно.

**Жич:**

Хяналт шалгалтын ажлын хэсгийн 1996-2009 оны статистик мэдээллийг УИХ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, Байнгын хороод тус бүрээр ангилан дэлгэрэнгүй байдлаар хавсаргав.

\*\*\*

**Ашигласан материал**

УИХ-ын даргын захирамж:

1. Данс: 4. ХН-84, 213, 258, 193, 212, 140, 141, 117, 196, 182, 170, 176, 251, 259, 125, 251, 156
2. Данс: 5. ХН-164, 125, 209, 185, 205, 254, 261, 252, 178, 182, 274, 285, 200, 194, 200, 230, 161, 228,
3. Данс: 6. ХН-193, 285, 249, 264, 250, 230, 90, 200, 153, 289, 296, 200, 146, 250, 324, 103, 245,

УИХ-ын тогтоол болон Байнгын хороодын хуралдааны тэмдэглэлүүд:

- <http://intra.parliament.mn> 2001-2008 он

УИХ -ын үйл ажиллагааны тайлан:

1. Данс 4: ХН-1576 1996-2000 онд хийсэн Хяналт шалгалтын дүнгийн танилцуулга мэдээ
2. Данс 5: ХН-1844 УИХ-ын үйл ажиллагааны нэгдсэн тойм
3. Данс 6: ХН-1880 УИХ-ын Хянан шалгах чиг үүргийн чиглэлээр зохион байгуулсан ажлын тухай танилцуулга
4. Данс 6: ХН-619 2000-2004 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны нэгдсэн тойм
5. Данс 6: ХН-1874 2004-2008 оны УИХ-ын үйл ажиллагааны тайлан, нэгдсэн тойм
6. Данс 6: ХН- 1788 Байнгын хорооны ажлын тайлан 2004-2008 он
7. Данс 6: ХН- 1772 Байнгын хорооны ажлын тайлан 2004-2008 он
8. Данс 6: ХН- 1590 Хянан шалгах үйл ажиллагааны статистик мэдээ 2005-2006 он

\*\*\*

Байнгын хорооны тогтоолууд:

1. Данс 5: ХН- 494	28. Данс 5: ХН- 594	55. Данс 6: ХН- 1405
2. Данс 5: ХН- 996	29. Данс 5: ХН- 1101	56. Данс 6: ХН- 1775
3. Данс 5: ХН- 1449	30. Данс 5: ХН- 1526	57. Данс 6: ХН- 154
4. Данс 5: ХН- 1751	31. Данс 5: ХН- 1792	58. Данс 6: ХН- 483
5. Данс 5: ХН- 494	32. Данс 5: ХН- 198	59. Данс 6: ХН- 937
6. Данс 5: ХН- 142	33. Данс 5: ХН- 609	60. Данс 6: ХН- 1398
7. Данс 5: ХН- 513	34. Данс 5: ХН- 1114	61. Данс 6: ХН- 1769
8. Данс 5: ХН- 1013	35. Данс 5: ХН- 1548	62. Данс 6: ХН- 119
9. Данс 5: ХН- 1461	36. Данс 5: ХН- 1428	63. Данс 6: ХН- 119
10. Данс 5: ХН- 1461	37. Данс 5: ХН- 1968	64. Данс 6: ХН- 160
11. Данс 5: ХН- 1759	38. Данс 6: ХН- 119	65. Данс 6: ХН- 495
12. Данс 5: ХН- 150	39. Данс 6: ХН- 887	66. Данс 6: ХН- 946
13. Данс 5: ХН- 523	40. Данс 6: ХН- 1363	67. Данс 6: ХН-1420
14. Данс 5: ХН- 1041	41. Данс 6: ХН- 1751	68. Данс 6: ХН-1778
15. Данс 5: ХН- 1476	42. Данс 6: ХН- 132	69. Данс 6: ХН-163
16. Данс 5: ХН- 1765	43. Данс 6: ХН-472	70. Данс 6: ХН-507
17. Данс 5: ХН- 164	44. Данс 6: ХН-896	71. Данс 6: ХН-960
18. Данс 5: ХН- 554	45. Данс 6: ХН- 1377	72. Данс 6: ХН-1428
19. Данс 5: ХН- 1061	46. Данс 6: ХН- 1756	73. Данс 6: ХН-1783
20. Данс 5: ХН- 1504	47. Данс 6: ХН- 137	74. Данс 6: ХН-436
21. Данс 5: ХН- 1778	48. Данс 6: ХН- 452	75. Данс 6: ХН-907
22. Данс 5: ХН- 181	49. Данс 6: ХН- 909	76. Данс 6: ХН-441
23. Данс 5: ХН- 574	50. Данс 6: ХН-1387	77. Данс 6: ХН-446
24. Данс 5: ХН-1081	51. Данс 6: ХН-1763	78. Данс 6: ХН-503
25. Данс 5: ХН- 1517	52. Данс 6: ХН- 145	79. Данс 6: ХН-933
26. Данс 5: ХН- 1786	53. Данс 6: ХН- 465	
27. Данс 5: ХН- 191	54. Данс 6: ХН- 918	

\*\*\*

## Хавсралт - 1

## Улсын Их Хурлын даргын захирамжаар хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл (1996-2008)

Д/д	Ажлын хэсэг байгуулсан шийдвэр, огноо • Ямар асуудлаар шалгалт хийсэн	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /УИХ-ын гишүүд, бусад албан хаагч/	Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал	Гаргасан шийдвэр	Тайлбар
1.	УИХ-ын даргын 1996.07.23-ны 43 тоот захирамж • Ардын эрх сонин төрийн төв хэвлэхээс татгалзсан нь хууль зүйн үндэстэй эсэх	Т.Эрдэнэбилэг Д.Баттулга Л.Лувсан-Очир Ч.Отгонбаяр Д.Цогт-Очир Ц.Шаравдорж	1996.09.03-ны өдөр Байнгын хорооны болон чуулганы хуралдаанаар хэлэлцсэн	УИХ-ын 1996.09.03-ны өдрийн 45 тоот тогтоол гаргасан	1996.08.07-ны дотор УИХ-д танилцуулах (ТББХ)
2.	УИХ-ын даргын 1996 оны 83 тоот захирамж • 1992-1996 онд төрөөс баримтлах мөнгөний бодлого бусад асуудал	Э.Бат-Үүл Р.Амаржаргал Р.Бадамдамдин А.Ганбаатар Ү.Наранцэцэг Р.Содхүү Б.Сонимпил Н.Лонжид	1997.02.13-ны өдөр Байнгын хорооны хурлаар хэлэлцээд	ТСМЗББХ-ны 1997.02.13-ны 10/029 тоот тогтоол гаргасан	1996.11-р сард Төсөв санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороонд танилцуулах
3.	УИХ-ын даргын 1997 оны 78 тоот захирамж • Хэвлэл, мэдээллийн шүүмжлэлийн мөрөөр	С.Батчулуун Батж.Батбаяр Б.Дэлгэрмаа Н.Түвшинтөгс Д.Баттулга Д.Батнасан Ж.Бямбадорж Р.Бадамдамдин	Хууль зүйн байнгын хорооны хурлаар 1997 оны 7-р сард хэлэлцсэн	Байнгын хорооны 07 тоот тогтоол гарсан	1997 оны 6-р сард УИХ-д танилцуулах (ХЗБХ)
4.	УИХ-ын даргын 1998 оны 75 тоот захирамж • СББ-ийг Голомт банктai нийлүүлснийг шалгах	Д.Дэмбэрэл А.Базархүү Д.Батнасан А.Ганбаатар Ж.Гомбожав О.Дашбалбар	Төсөв, Эдийн засгийн байнгын хорооны хурлаар болон УИХ-ын чуулганаар хэлэлцсэн	УИХ-аар хэлэлцэн Сэргээн Босголтыг Голомт банктai нэгтгэсэн 80-р тогтоолыг хүчингүй болгосон	ТБХ
5.	УИХ-ын даргын 1998.06.09-ний 07 тоот захирамж • Улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжигдсэн төслийг шалгах	Ц.Төмөртоогоо Н.Батцэрэг М.Зэнээ Ж.Отгонбаяр	Шалгалтын дүнг холбогдох байнгын хорооны гишүүдэд танилцуулсан.		1998.07.01-ний дотор холбогдох байнгын хороонд танилцуулах (ЗЗБХ)
6.	УИХ-ын даргын 1998.07.20-ны 93 тоот захирамж • Шалгалтын материалтай нарийвчлан танилцах	Н.Алтанхуяг Ё.Гэрэлчулуун Т.Очирхүү Р.Сандалхан Т.Эрдэнэбилэг	1998 оны 8-р сард ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж Эдийн засгийн байнгын хорооны илтгэх хуудсаар танилцуулсан		1998.07.28-ны дотор танилцуулах (ЗЗБХ)



7.	УИХ-ын даргын 1999.09.19-ны 92 тоот захирамж <ul style="list-style-type: none"> <li>Монгол-Оросын хамтарсан үйлдвэрүүдийн үүсч бий болсон асуудлыг шалгах</li> </ul>		Э.Бат-Үүл Б.Баабар С.Ламбаа Д.Цэвээнжав Ч.Улаан Д.Энхтайван	Ажлын хэсэг шалгаж нэгдсэн илтгэх хуудас бичиж бэлэн болгосон	Байнгын хорооны болон Их Хурлаар хэлэлцээгүй байна.	9-р сард багтаан УИХ-д танилцуулах (ТББХ)
8.	УИХ-ын даргын 2000.08.14-ны №17 захирамж <ul style="list-style-type: none"> <li>Монголбанкинд банкны хууль тогтоомжийн хэрэгжилт Монголбанк, Засгийн газар хоорондын зээлийн асуудал, Монголбанкны бүтэц зохион байгуулалт, боловсон хүчний тогтвор суурьшилт, ажлын хариуцлагын асуудлын шалгах</li> </ul>		<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Р.Содхүү <b>Гишүүд:</b> Б.Шаравсамбуу Н.Содномдорж Ц.Оюунбаатар	2001.11.16-нд Ажлын хэсгийн хийсэн шалгалтын танилцуулга ЭЗБХ-нд ирүүлсэн байна.	-	2000 оны 8дугаар сард багтаан Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах
9.	УИХ-ын даргын 2001.07.18 №136 захирамж <ul style="list-style-type: none"> <li>“Эрдэнэт” үйлдвэрт шалгалт хийх</li> </ul>		<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ц.Шаравдорж <b>Гишүүд:</b> Д. Цэвээнжав Д.Мөрөн Р.Амарсайхан Д.Батжаргал Ч.Мөнхбаяр Р. Чингис Д.Махбал	2001.12.17-ний УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэж 2002.05.08-нд Хууль зүй, эдийн засгийн байнгын хороонд хэлэлцсэн. УИХ-ын нэгдсэн хуралдаанаар БХ-ны дүгнэлтийг хэлэлцээд тогтоол гаргасан.	УИХ-ын 2002.05.10 №16 тогтоол гаргасан.	-
10.	УИХ-ын даргын 2002.04.12 №59 тоот захирамж <ul style="list-style-type: none"> <li>Үндэсний статистикийн газарт Статистикийн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах</li> </ul>		<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Б.Шаравсамбуу <b>Гишүүд:</b> О.Нигамет Р.Цагаанхүү Д.Махбал Д.Отгон Э.Энхнаран	Эдийн засгийн байнгын хороонд УСГ-ын үйл ажиллагааны тайланг шалгасан дүнг хэлэлцсэн.	Эдийн засгийн байнгын хорооны 2002.06.06 №10 тогтоол гарсан.	2002 оны 4 дүгээр сарын 25-ны дотор багтаан явуулж дүнг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах
11.	УИХ-ын даргын 2002.07.17 №113 захирамж <ul style="list-style-type: none"> <li>Дулаан, цахилгааны үнэ нэмсэн үндэслэлийг судалж, дүгнэлт хийх</li> </ul>		<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Б.Шаравсамбуу <b>Гишүүд:</b> Р.Амарсайхан А.Базархүү Ц.Дамиран нарын 12 хүн	2002.07.25-нд ажлын хэсэг шалгасан тухайгаа илтгэх хуудсаар танилцуулсан байна.	-	-
12.	УИХ-ын даргын 2002.08.30 №131 захирамж	Монголбанкинд Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийг хэрэгжилтийн байдлыг шалгах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Т.Очирхүү <b>Гишүүд:</b> Д.Дэмбэрэлцэрэн Н.Энхболд	Тодорхойгүй.	Тодорхойгүй.	2002 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс 10 хоногийн хугацаанд зохион байгуулах



13.	<p>УИХ-ын даргын 2002.11.14 №179 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>“Газрыг шударгаар хувьцах”-өөс санаачлан зохион байгуулсан цуглаан болон уг цуглааныг албадан тараах явцад хууль зөрчигдсөн эсэхийг шалгах</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Д.Дэмбэрэл</p> <p><b>Гишүүд:</b> Ш.Бадам Д.Базарсад Ж.Наранцацралт Б.Эрдэнбат</p>	2002.12.03-ны өдөр Хууль зүйн байнгын хороо хэлэлцсэн.	Хууль зүйн байнгын хорооны 2002.12.03-ны 14 тогтоол гаргасан.	-
14.	<p>УИХ-ын даргын 2002.12.11 №195 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>Төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаа болон хууль тогтоомж зөрчиж төрийн өмчийн эд хөрөнгийг үрэгдүүлсэн, идэж ашигласан нь тогтоогдсон хүмүүст төлбөр ногдуулж барагдуулах, хариуцлага тооцох, хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, шударга бус явагдсан зарим хувьчлалыг залруулах, дахин хувьчлах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн байдлыг Төрийн өмчийн хороонд шалгах</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Н.Ганбямба</p> <p><b>Гишүүд:</b> Д.Арвин Л.Даваацэдэв Б.Долгор Ц.Оюунбаатар Н.Тогтох</p>	Тодорхойгүй.	Тодорхойгүй.	2002 оны 12 дугаар сарын 11-ээс 2003 оны 1 дүгээр сарын 3-ыг хүртэл хугацаанд багтаан явуулах
15.	<p>УИХ-ын даргын 2003.07.25 №98 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>УИХ-ын гишүүн Л.Гүндалайг баривчилсан асуудлыг судлах</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ц.Шаравдорж</p> <p><b>Гишүүд:</b> Б.Баттулга Д.Мөрөн</p>			
16.	<p>УИХ-ын даргын 2004.12.15-ны №139 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>Тагнуулын ерөнхий газрын зарим ажилтан төрийн нууцын тухай болон Гүйцэтгэх ажлын тухай хуулийг зөрчсөн талаар иргэн Л.Санжаасүрэнгийн гаргасан гомдол, хүний эрхийг зөрчсөн эсэхийг шалгуулах талаар Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн хүсэлтийг шалгах</li> </ul>	<p><b>Гишүүд:</b> Н.Энхболд Р.Амаржаргал Р.Гончигдорж</p>	Тус захирамжийн биелэлтийн талаарх мэдээлэл нь нууцын зэрэглэлд хамаарах тул мэдээлэл өгөх боломжгүй юм байна.		2005 оны 1 дүгээр сарын 9-ний дотор АБГБХ-д танилцуулах удирдамжтай
17.	<p>УИХ-ын даргын 2005.05.05-ны №77 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгонд худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 58 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ц.Дамиран</p> <p><b>Гишүүд:</b> С.Баярцогт Т.Очирхүү А.Бакей</p>	Тодорхойгүй.	Тодорхойгүй.	2005 оны 6 дугаар сард багтаан УИХ-ын холбогдох байнгын хороонд танилцуулах

18.	<p>УИХ-ын даргын 2006.02.22 №28 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>Улсын Тусгай хамгаалалтын газар нутагт иргэн байгууллага аж ахуйн нэгжид газар олгосон байдлыг шалган, судалж санал дүгнэлт боловсруулах</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Т.Бадамжунай <b>Гишүүд:</b> Э.Батүүл Ц.Жаргал Р.Нямсүрэн Б.Батбаяр О.Баяраа Д.Энхгэрэл Д.Цэдэниш</p>	<p>2006.05.05-нд Ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийг БОХХААБХ-д танилцуулсан.</p>	<p>2006.11.14-нд БОХХААБХ-ны Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай 6/7181 албан тоотыг БОЯ-ны сайд И.Эрдэнэбаатарт хүргүүлсэн.</p>	<p>2006 оны 4 дүгээр сарын 15-ны дотор танилцуулах</p>
19.	<p>УИХ-ын даргын 2006 .05.19-ний №79 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>УИХ-д ажлаа шууд тайлагнадаг байгууллагуудын төсвийн төлөвлөлт зарцуулалтын байдалтай танилцаж, тэдгээр байгууллагуудын санхүүгийн байдлыг бэхжүүлэх талаар санал боловсруулах</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Д.Дэмбэрэл <b>Гишүүд:</b> Г.Адъяа Ж.Батхуяг Д.Батэрдэнэ Ч.Сономцэрэн Р.Раш</p>	<p>2006.11.30-нд ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулсан.</p>	<p>Тодорхой саналуудыг 2007 оны улсын төсөвт тусгуулсан.</p>	<p>2006 оны 5 дугаар сард багтаан бэлэн болгож, Төсвийн болон Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулах</p>
20.	<p>УИХ-ын даргын 2006.06.12-ны №90 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>Төв банк /Монголбанк/-ны үйл ажиллагаатай холбогдуулсан хууль тогтоомжийн хэрэгжилт, Монгол банкны ерөнхийлөгчөөс бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрүүд түүний үр дүн, Монголбанкны үйл ажиллагаа болон өөрийн хөрөнгө оруулгын хувиарлалт ашиглалты байдлын хянаж шалгах, банкны тухай болон Төв банк /Монголбанкны/-ны ухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Б.Эрдэнсүрэн <b>Гишүүд:</b> Р.Амаржаргал Д.Ганхуяг Г.Занданшатар М.Зоригт Ч.Содномцэрэн Ц.Шаравдорж Б.Цэрэнбалжир Г.Цэрэнпүрэв</p>	<p>2006.10.19-нд Ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийг ЭЗБХ-нд танилцуулсан.</p>	<p>УИХ-ын 2006 оны 10 дугаар сарын 24-ний өдөр ажлын хэсгийн мэдээлэл.</p>	<p>2006 оны 8 дугаар сард багтаан танилцуулах</p>
21.	<p>УИХ-ын даргын 2006.06.19-ний №97 захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>Төсвийн байгууллагаас иргэд байгууллагуудад учруулсан шүүхийн шийдвэр бүхий хохирлыг барагдуулах асуудлыг судлан үзэж санал, дүгнэлт болвруулан УИХ-д танилцуулах</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ц.Шаравдорж <b>Гишүүд:</b> Б.Батжаргал Х.Пүрэвсүрэн Д.Мөнхгэрэл Ц.Нанзаддорж Д.Өлзийбат</p>			<p>2006 оны 7 дугаар сарын 20-ны дотор УИХ-д танилцуулах</p>
22.	<p>УИХ-ын даргын 2006.06.23 №99 тоот захирамж</p> <ul style="list-style-type: none"> <li>Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгаж иргэдийг ноцтой хохироосон үйлдэл гаргах болсон шалгаан, нөхцөлийн талаар дүгнэлт гаргах</li> </ul>	<p><b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Д.Ганхуяг <b>Гишүүд:</b> Р.Бадамдамдиин Ч.Раднаа Р.Раш Д.Туяа З.Энхболд</p>	<p>Ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг ЭЗБХ-нд 2007.05.01 №10 хуралдаанд танилцуулсан.</p>	<p>УИХ-ын 2007.05.08-ны өдрийн хуралдаанд ЗГ-ын ажлын хэсгийн мэдээлэл.</p>	<p>2006 оны 7 дугаар сарын 5-ны дотор УИХ-д танилцуулах</p>

23.	УИХ-ын даргын 2006.06.23 №100 тоот захирамж <ul style="list-style-type: none"> <li>Албан үүрэгтэй нь холбогдуулан төрийн өндөр албан тушаалтны амь насанд халдсан онц хүнд гэмт хэрэг гарах болсон нөхцөл, шалтгааныг судлан үзэж дүгнэлт гаргах</li> </ul>	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Г.Адьяа <b>Гишүүд:</b> Э.Бат-Үүл Ц.Баярсайхан Ц.Ламбаа Р.Нямсүрэн Ц.Шаравдорж	-	УИХ-ын 2006.07.10-ны өдрийн хуралдаанд ажлын хэсэг мэдээлэл хийсэн.	2006 оны 7 дугаар сарын 5-ны дотор УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулах
24.	УИХ-ын даргын 2006.06.28 №102 тоот захирамж <ul style="list-style-type: none"> <li>Улсын хил гаалиар төмрийг хууль бусаар экспортын талаар төлөвлөөгүй гаргасан эсэх асуудлыг судлан үзэж, дүгнэлт гаргах</li> </ul>	<b>Ажлын хэсгийн ахлагч</b> З.Энхболд <b>Гишүүд:</b> Д.Арвин М.Зоригт Н.Цогтсайхан	2006.06.09-нд УИХ-ын нэгдсэн хуралдаанд сонссон.	-	2006 оны 8 дугаар сард УИХ-д танилцуулах
25.	УИХ-ын даргын 2006.08.07-ны №121 захирамж <ul style="list-style-type: none"> <li>УИХ-ын гишүүн агсан С.Зориг амь насыг хохироосон гэмт хэргийн шалгалтын явцтай танилцах, энэхүү үйл ажиллагаанд шаардлагатай туслалцаа дэмжлэг үзүүлэх</li> </ul>	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> М.Зоригт <b>Гишүүд:</b> Сү.Батболд Р.Амаржаргал Ц.Сүхбаатар Р.Эрдэнэбүрэн	Тус захирамжын биелэлтийн талаарх мэдээлэл нь нууцын зэрэглэлд хамаарах тул мэдээлэл өгөх боломжгүй юм байна.	-	Олон Улсын Парламентын Холбоо хэлэлцсэн.
26.	УИХ-ын даргын 2006.09.11-ний №136 захирамж <ul style="list-style-type: none"> <li>Газрын тухай хуулийн 44.1-р зүйл, 56.7 дахь хэсэг сууц өмчлөгчийн холбооны эрх зүйн байдал нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын эд хөрөнгийн тухай хууль 7.2.8, 7.2, 7.10. 12.4,8 дахь заалт хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2005 оны №43-р тотоолын хэрэгжилтийг шалган судалж, санал дүгнэлт гаргах</li> </ul>	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ц.Мөнх-Оргил <b>Гишүүд:</b> Сү.Батболд Б.Мөнхтуяа С.Оюун	2006.10.25-нд Хяналт шалгалтын хэлтэст ажлын хэсгийн материал ирүүлсэн.	-	2006 оны 10 дугаар сард багтаан УИХ-д танилцуулах
27.	УИХ-ын даргын 2007.05.03-ны №77 захирамж <ul style="list-style-type: none"> <li>Банкны тухай хууль тогтоомжыг Монгол банкны үйл ажиллагаанд шалган дүгнэлт гаргах</li> </ul>	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Д.Ганхуяг <b>Гишүүд:</b> Ж.Батхуяг М.Зоригт Ч.Раднаа	УИХ-ын 2007.10.17-ны нэгдсэн чуулганд ажлын хэсгийн шалгалтын дүнг танилцуулсан	-	
28.	УИХ-ын даргын 2007.07.02-ны №125 захирамж <ul style="list-style-type: none"> <li>2007 оны 6 дугаар сарын 14-ий өдөр ой, хээрийн түймэр унтраах томилгоотой албан үүргээ гүйцэтгэж явсан төрийн албан хаагчид сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт нисдэг тэрэгний осолд өртөн амь үрэгдэхэд хүрсэн нөхцөл байдлыг судалж дүгнэлт гаргах</li> </ul>	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ж.Гүррагчаа <b>Гишүүд:</b> Р.Амаржаргал Ц.Жаргал Л.Одончимэд С.Оюун Ц.Сүхбатааар Р.Эрдэнэбүрэн	УИХ-ын дарга Д.Лүндээжанцанд ажлын хэсгийн шалгалтын явцын мэдээллийг 2007.08.17-ны 5/4948 албан тоотоор танилцуулсан.	-	2007 оны 7 дугаар сарын 15-ны дотор УИХ-д танилцуулах

29.	УИХ-ын даргын 2008.07.03-ны №72 захирамж • Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт онц байдал тогтооход хүрсэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Д.Дондог <b>Гишүүд:</b> Ц.Нямдорж Л.Гансүх Ц.Мөнх-Оргил С.Баярцогт Л.Гантөмөр	Тодорхойгүй	Тодорхойгүй	2008 оны 7 дүгээр сарын 7-ны дотор УИХ-д танилцуулах
30.	УИХ-ын даргын 2009.03.24-ний №62 захирамж • Хилийн хяналтын байгууллагуудын болон хилийн боомтын үйл ажиллагаа, холбогдох олон улсын гэрээгэрээ, хэлэлцээр, дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах		2009.04.20-нд Ажлын хэсэг Замын-Үүд, Гашуунсухайт, Хангимандал дахь хилийн боомтуудын үйл ажиллагаатай танилцаж, санал дүгнэлт боловсруулан Байнгын хорооны хуралдаанд оруулахаар бэлтгэсэн.		
31.	УИХ-ын даргын 2009.07.24-ний №126 захирамж • 2008 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Онц байдал тогтооход хүргэсэн нийтийн эмх замбараагүй байдлын үед нийгмийн дэг журам сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд хэрхэн ажилласан, тэдгээрийн харилцан үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх		Тодорхойгүй.	Тодорхойгүй	

\*\*\*

Хавсралт - 2

**Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээ \1996-2009\**

Д/д	Ажлын хэсэг байгуулсан шийдвэр, огноо • Ямар асуудлаар шалгалт хийсэн	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /УИХ-ын гишүүд, бусад албан хаагч/	Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал	Гаргасан шийдвэр	Тайлбар
1.	1998.01.05-ны № 7 тогтоол • Засгийн газар, Дэд бүтцийн хөгжлийн яам, Ойрын ирээдүйд Монгол Улсад гадаадаас оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт болох Эгийн голын усан цахилгаан станц барих төслийн хэрэгжилтэд УИХ-аас тавих хяналтыг хэрэгжүүлэх	Н.Түвшинтөгс / ахлагч/ Л.Болд С.Зориг Ж.БатдэлгэрУТГ	Төслийн хэрэгжилтийн явцын талаар шалгасан дүнг Байнгын хорооны даргад танилцуулсан	шийдвэр гараагүй	

2.	1998.01.08-ны № 9 тогтоол • «Зэсийн баяжмал худалдах тухай»	С.Баярцогт / Ахлагч/ Ё.Адилбиш О.Дашбалбар Ц.Төмөртоого Б.Өнөбаатар /ТГ7 Ж.Батдэлгэр/ ТГ/	Ажлын хэсэг ажиллаж байгаад жич мэргэжлийн хүмүүс оруулсан ажлын хэсэг байгуулахаар болсон	шийдвэр гараагүй	
3.	1998.02.20-ний № 11 тогтоол • «Навигацийн үйлчилгээний хураамжаас чөлөөлөх тухай» МУ-ын Засгийн газрын 1997. 12.10-ны 237,238-р тогтоолын хууль зүйн үндэслэлийг шалгах, онгоц худалдан авах гэрээний тооцоог нягтлан үзэх, мэргэжлийн дүгнэлт гаргах	Б.Олонбаяр / ахлагч/ П.Гончиг/СЯ/ Энхбат/ХЗЯ/ Д.Баясгалан / ИАТУГ/ М.Зоригт “Эйр Монгол” компани Ц.Лхагва /МИАТ/	Байнгын хорооны хурлаар хэлэлцээгүй.	Шийдвэр гараагүй.	Ажлын хэсэг өөрсдийн чиглэлээр танилцаж материал бүрдүүлсэн.
4.	1998.02.18-ны № 10 тогтоол • Сангийн яам, ГХЯ, Япон Улсаас үзүүлж буй төслийн бус буцалтгүй тусламжийн хэрэгжилт, сангийн бүрдэлтийг шалгах	Д.Дашпүрэв / ахлагч/ С.Төмөр-Очир О.Энхтуяа	Шалгалтын талаар танилцуулга бэлтгэж байнгын хороонд танилцуулсан.	Шийдвэр гараагүй.	
5.	1999.02.01-ний №03 тогтоол • Дэд бүтцийн хөгжлийн яамны эрчим хүчний систем, Эрчим хүчний ситөмийн хувьчлалыг шалган тогтоох	Н.Түвшинтөгс Р.Амаржаргал А.Болат Н.Тогтох Р.Сандалхан С.Батхуяг Д.Цог	Ажлын хэсэг ажиллаагүй	-	
6.	1999.02.01-ний № 03 тогтоол • Төмөр замын Хэрэг эрхлэх газар, Төмөр замын хувьчлалын тухай	Ц.Шаравдорж О.Дашбалбар Ж.Бямбадорж Ц.Төмөртоого	Ажлын хэсэг ажиллаагүй	-	
7.	1999.02.01-ний №03 тогтоол • Иргэний агаарын тээврийг удирдах газар МИАТ компани, МИАТ компанийн хувьчлалын талаар	Т.Эрдэнэбилэг Т.Султан О.Энхтуяа Ц.Шаравдорж	Ажлын хэсэг Дэд бүтцийн яамнаас холбогдох судалгаа авсан дүгнэлт гаргаагүй		
8.	1999.02.01-ний №03 тогтоол • Эрдэнэт комбинат, Эрдэнэт комбинатын хувьчлалын тухай шалгах	С.Оюун О.Дашбалбар Д.Дашпүрэв Р.Содхүү Ч.Улаан Д.Баярсайхан Ш.Ганболд	Ажлын хэсэг ажиллаагүй	-	
9.	1999.02.01-ний №03 тогтоол • Дэд бүтцийн хөгжлийн яам, Эгийн голын усан цахилгаан станцын барих төслийн тендер шалгаруулалтыг шалгах	Ё.Адилбиш Т.Ганди Н.Түвшинтөгс Д.Дашпүрэв Ш.Ганболд С.Батхуяг	Шалгалтын талаар Байнгын хорооны хуралдаанд илтгэх хуудсаар танилцуулсан.	Байнгын хорооноос тодорхой шийдвэр гараагүй	

10.	1999.02.01-ний №03 тогтоол • Хууль зүйн яамны тендер шалгаруулалтын комисс, Казино ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрлийг тендер зарлаж шалга-руулсан байдлыг шалгах	Ц.Ганхуяг Д.Энхтайван Ч.Отгонбаяр Ш.Ганболд	Тодорхойгүй.	Тодорхойгүй.	
11.	1999.2.1-ний № 03 тогтоол • Сангийн яам, Гадаад харилцааны яам, Гадаадын хөрөнгө, Гадаад улсаас Монгол Улсад үзүүлсэн зээл тусламжийн зарцуулалтын байдлыг шалгах	С.Төмөр-Очир С.Оюун Т.Эрдэнэбилэг Т.Очирхүү Д.Цог	СЯ, ГХЯ-аас холбогдох судалгаа тооцоо гаргаж авсан	шийдвэр гараагүй	
12.	1999.2.12-ны №04 тогтоол • Хилийн цэр-гийн удирдах өрөнхий газар, Хилийн тухай хуулийн хэрэгжилтийн тухай	Ц.Ганхуяг Ц.Шаравдорж О.Дашбалбар Ж.Батдэлгэр З.Өлзийсайхан Д.Бавуудорж Ч.Орсоо Б.Жамбалдорж	Байнгын хорооны хуралдаанд шалгал-тын дүнг талаар танилцуулсан.	Байнгын хорооноос шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авах албан бичиг өгсөн	Засгийн газраас тодорхой хариу өгсөн
13.	1999.9.28-ны № 10 тогтоол • Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын үйл ажиллагааны гадаад бодлогын хэрэгжилт 1998 оны төсвийн зарцуулалтыг шалгах	Ц.Ганхуяг Ж.Бямбадорж Ж.Батдэлгэр Д.Ламжав Д.Өлзийтогтох Д.Лхам	1998 оны төсвийн зар-цуулалтын байдлыг шалгаж Байнгын хорооны хуралд танилцуулсан	-	
14.	1999.11.03 №13 тогтоол • ГХЯ, Гадаад харилцааны яамны 1998 оны төсвийн гүйцэтгэлийг шалгаж, танилцуулах	С.Оюун Т.Султан	Шалгалтын талаар Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж танилцуулсан		
15.	1999.11.03-ны №13 тогтоол • БХЯ, Батлан хамгаалах яамны 1999 оны төсвийн гүйцэтгэлийг шалгаж танилцуулах	Ц.Ганхуяг Ж.Бямбадорж	Тодорхойгүй	Тодорхойгүй	
16.	2002.02.20-ны №01 тогтоол • Байнгын хорооны УИХ-ын 2001 оны намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд хийх ажлын төлөвлөгөөний дагуу Монгол Улсаас Япон, БНСУ-тай байгуулсан ОУ-ын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явц байдлыг шалгах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ш.Гунгаадорж - УИХ-ын гишүүн <b>Гишүүд:</b> Б.Баттулга-УИХ-ын гишүүн У.Хүрэлсүх-УИХ-ын гишүүн М.Элбэгдорж –референт Д.Энхгэрэл-УИХТГ-т зохион байгуулагч	Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зөвхөн хоёр улсаар хязгаарлахгүйгээр Монгол Улс нь хичнээн улс оронтой гэрээ, хэлэлцээр хийснийг нэгтгэж байж шалгахаар тохиролцоод хойшлуулсан.	2008 оны 5 дугаар сард СЯ-наас 1992-2008 онд ЗГ-ын гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлт зэргийг БХ-ны ажлын албанд хүргүүлсэн.	Удирдамжтай.

17.	2007.02.07-ны №01 тогтоол • Асгатын мөнгөний орд газрын ашиглах асуудлаар байгуулсан гэрээ хэлэлцээр, түүнийг цуцалсан тухай асуудлыг шалгаж, дүгнэлт гаргах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> К.Сайраан - УИХ-ын гишүүн <b>Гишүүд:</b> Л.Гансүх-УИХ-ын гишүүн Д.Идэвхтэн-УИХ- ын гишүүн С.Оюун-УИХ-ын гишүүн Ц.Шаравдорж- УИХ-ын гишүүн	Ажлын хэсгийн дүгнэлт 2007.04.24- ний өдөр гарсан. / Ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зураагүй байна/ Шалгалтын дүнг 2009.10.15-ны өдрийн АБГББХ, ХЗБХ-ны хамтарсан хурлаар хэлэлцсэн.	2009.10.15- ны өдрийн АБГББХ, ХЗБХ- ны хамтарсан тогтоол гарсан.	Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний орд газартай газар дээр нь очиж танилцахаар ажлын хэсгийн хөтөлбөр гарсан.
18.	2007.08.08-ны №11/06 тогтоол • Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шалган, танилцах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ч.Авдай - УИХ-ын гишүүн <b>Гишүүд:</b> 17 Ажлын хэсэгт ТЕГ, ГХЯ, БХБЯ, НХХЯ, ЗТАЖЯ, ХЗДХЯ, ГИХАЭА, БОЯ, ХХЕГ, ЦЕГ-аас хүмүүсийг татан оролцуулсан.	2007.08.14-ний өдөр эхний хуралдаанаа хийж, салбар салбараар дэд хэсгүүд болгон ажиллахаар тогтсон. Дэд хэсэг нь дүгнэлтүүдээ нэгтгэж, АБГББХ, НББСШУБХ- ны хамтарсан хуралдаанд оруулж хэлэлцүүлсэн.	2007.12.19- ний өдрийн АБГББХ, НББСШУБХ- ны хамтарсан хуралдаанаар тогтоол гаргасан.	Удирдамжтай.  Хуулиудад өөрчлөлт оруулах, шаардлагатай ийм хуулиудад судалгаа хийх өргөн хүрээтэй ажлын хэсгийг шинэчлэн зохион байгуулж ажиллуулахаар шийдвэрлэсэн
19.	2008.01.09-ны № 01 тогтоол • “Хүний аюулгүй байдал ба химийн хорт бодис” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийн дүн, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн хэрэгжилтийг Дархан- Уул аймгийн Хонгор суманд танилцсан дүнг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч- Б.Мөнхтуяа -УИХ-ын гишүүн, БХ-ны дарга	2007.12.11-ний өдөр “Хүний аюулгүй байдал ба химийн хорт бодис” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг явуулсан. 2008.01.08-ны өдөр Дархан-Уул аймгийн Хонгор суманд УИХ-ын гишүүн, Байнгын хорооны дарга Б.Мөнхтуяа, УИХ-ын гишүүн М.Энхсайхан, Б.Эрдэнэбүрэн, Б.Цэрэнбалжир нар очиж газар дээр нь ажилласан.	-2007.05.15-ны өдрийн №05 тоот “Химийн хорт болон аюултай бодист тавих хяналтыг сайржуулах тухай” БХ-ны тогтоол гарсан. 2008.01.09- ны өдрийн Байнгын хорооны хурлаар уг асуудлаар мэдээлэл сонссон. 2008.01.09- ний өдрийн №01 тоот “Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах тухай” БХ-ны тогтоолыг Засгийн газарт хүргүүлсэн.	Ажлын хэсэг 3 үе шаттайгаар үйл ажиллагаагаа тодорхойлсон.
20.	2008.01.25-ны № 02/01 тогтоол  Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдмэл бодлогын салшгүй хэсэг эмийн үндэсний бодлогын болон эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж дүгнэлт гаргах	Ажлын хэсгийн ахлагч - УИХ- ын гишүүн Л.Одончимэд, С.Ламбаа нар	2008.04.03- нд С.Ламбаа гишүүнтэй ажлын хэсэг эмийн сангуудын эрхлэгч нартай уулзалт ярилцлага хийсэн. -2008.04.08-нд Д.Туяа гишүүнтэй ажлын хэсэг нийслэлийн эмийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцсан. Холбогдох газруудаас албан тоот ирүүлсэн байна.	2008 сонгуулийн компанит ажил эхэлсэн тул ажлын хэсэг цаашид үргэлжлүүлэн ажиллаагүй.	Энэ чиглэлээр 2 ажлын хэсэг болон ажилласан.  /НББСШУБХ- той хамтарсан



21.	<p>2008.01.25 № 03/01</p> <ul style="list-style-type: none"> <li>/БОХХААБХ-той хамтарсан/ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын хэрэгжилт, Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг экологийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулан зохицуулж ажиллаж байгаа болон Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаа эсэх, агаар, ус, хөрсний бохирдлын улмаас хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд учирч болох хор уршигаас урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүн, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах</li> </ul>	Ажлын хэсгийн ахлагч - УИХ-ын гишүүн, БХ-ны дарга Б.Мөнхтуяа	2008.05.07-нд "Хүнсний аюулгүй байдал" нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.	Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран химийн хорт бодисын хор аюулын тухай баримт кино, химийн хорт бодисын хор аюултын талаар ард иргэдэд сурталчилгаа, таниулгыг Олон нийтийн радио, телевиз, арилжааны зарим телевизүүдээр гаргасан.	/НББСШУБХ-той хамтарсан
22.	<p>2008.01.25-ны № 04/02/ тогтоол</p> <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын хэрэгжилт, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулан зохицуулж ажиллаж байгаа болон энэ талаар зохион байгуулсан ажлын үр дүн, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж дүгнэлт гаргах</li> </ul>	Ажлын хэсгийн ахлагч - УИХ-ын гишүүн Л.Гантөмөр	2008.02.27-нд Л.Гантөмөр гишүүнтэй ажлын хэсэг хуралдсан. Ажлын хэсгээс Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хөтөлбөрийн үр дүнгийн тайлангийн товчоог гаргуулж, ажлын хэсгийн гишүүдэд тараасан.	2008 сонгуулийн компани т ажил эхэлсэн тул ажлын хэсэг цаашид үргэлжлүүлэн ажиллаагүй.	Холбогдох газруудын ажилтай танилцсан.  /БОХХААБХ-той хамтарсан
23.	<p>2008.10.29ний №02 тогтоол</p> <ul style="list-style-type: none"> <li>Монгол улсаас ОХУ-д суугаа элчин сайдын яамны 2 дугаар байрыг түрээсийн гэрээгээр ашиглуулсантай холбоотой асуудлыг шалгах</li> </ul>	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Б.Батбаяр	Тодорхойгүй	Тодорхойгүй	Ажлын хэсэг 2008.11.25-нд Байнгын хороонд танилцуулах шийдвэртэй.



24.	2009.01.09-ны №01/01 тогтоол • Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ш.Сайхансамбуу	Ажлын хэсгийн хуралдааныг 2 удаа хийсэ.н. Нийслэлийн газрын албаны хүмүүстэй уулзалт ярилцлага зохиох байгуулсан. СӨХДЗ-ийнхэнтэй уулзахаар бэлтгэж байгаа <b>/Ажил нь үргэлжилж байгаа/</b>		
25.	2009.01.09-ний №07 тогтоол • “Монгол Улс, ЗСБНОХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан 1971 оны нууц протокол”-ыг ОУ-ны гэрээ, Венийн конвенци болон Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх чиглэлээр байр сууриа Монгол Улсын Засгийн газраас	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Д.Ганхуяг	Хийгдэж байгаа.		2009.08.20-нд Байнгын хороонд танилцуулах
26.	2009.02.11-ны №04/02 тогтоол • Хилийн хяналтын байгууллагуудын болон хилийн зарим боомтын үйл ажиллагаа, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээр, дотоодын хууль тогтоомжуудын хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Х.Жекей	2009.04.10-нд Ажлын хэсэг Замын -Үүд, Гашуунсухайт, Хангимандал дахь хилийн боомтуудын үйл ажиллагаатай танилцаж, санал дүгнэлтээ боловсруулан Байнгын хороонд оруулахаар бэлтгэж байгаа. <b>/Ажлаа эхэлсэн үргэлжилж байгаа/</b>		
27.	2009.07.23-ны №08 тогтоол • Гал, усны гамшгийн үед Улаанбаатар хотын гэр хорооллын дэд бүтэц, үерийн усны далан, гүүр зэрэг нь иргэдийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа, Нийслэлийн засаг даргын Тамгын газраас агаарын бохирдолыг багасгах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, төсвийн хөрөнгийн зарцуулалт болон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг шалгах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Э.Мөнх-Очир	Уг асуудлыг холбогдох газрууд шалган танилцаж, санал дүгнэлтээ боловсруулан байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байгаа. <b>/Дуусаж байгаа/</b>	-	

28.	2009.09.02-ний №09 тогтоол • Гадаад орнуудын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Телемедициний төслүүдийн хэрэгжилтийг шалгах	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> С.Оюун	Уг асуудлыг Зүрх судасны төв, Эх нялхасын эрдэм шинжилгээний төвийн эх барих эмэгтэйчүүдийн клиникт танилцан, санал, дүгнэлт илтгэх хуудсаа боловсруулсан. Байнгын хорооны хуралдаан танилцуулахаар бэлтгэсэн. <b>/Дуусаж байгаа/</b>		
-----	--	--	--	--	--

\* \* \*

## Хавсралт - 3

**Улсын Их Хурлын Байгаль орчин Хүнс Хөдөө Аж Ахуйн Байнгын Хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл \1996 - 2008\**

Д/д	Ажлын хэсэг байгуулсан шийдвэр, огноо	Ямар асуудлаар шалгалт хийсэн	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /УИХ-ын гишүүд, бусад албан хаагч/	Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал	Гаргасан шийдвэр	Тайлбар
1.	1997.12.24-ны №11 тогтоол	ХААҮЯ бусад холбогдох байгууллагад Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт	<b>Ажлын хэсгийн ахлагч:</b> Ц.Ганхуяг <b>Гишүүд:</b> Ё.Гэрэлчулуун Ж.Отгонбаяр	Байнгын хорооны хурлаар ажлын хэсгийн дүнг хэлэлцсэн.	Тодорхойгүй.	
2.	1998.12.02-ны №08 тогтоол	ХХААЯ Улсын Нөөцийн газар, Улсын нөөцийн барааны хадгалалт, хамгаалалт, шинэчлэн сэлгэлт	Д.Батнасан Ж.Гомбожав Д.Хувьтөгөлдөр Ж.Батдэлгэр Ц.Банзрагч Д.Отгон Г.Ломбо Д.Лхам	1999.03.30-ны өдөр БОХХБХ-ны хурлаар хэлэлцэв.	1999.03.31-ний өдөр шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 01 тоот тогтоол гаргав.	
3.	1999.07.14-ны №05 тогтоол	ХААҮЯ, нийслэл бусад холбогдох байгууллага албанд Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт	Н.Батцэрэг Д.Батнасан Д.Бохьшарга Ж.Норовсамбуу Ж.Гомбожав	Ажлын хэсгийн дүнг хурлаар хэлэлцээгүй.	Тодорхойгүй	
4.	1997.07.14-ны №06 тогтоол	БОЯ холбогдох газруудад Дорнод, Сүхбаатар аймаг, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт	Ж.Гомбожав С.Билэгсайхан Ж.Батдэлгэр Дашгирав Ш.Ринчин	Ажлын хэсгийн дүнг байнгын хорооны гишүүдэд танилцуулга бэлтгэж тараасан.		

5.	1999.12.07-ны №11 тогтоол	ХААҮЯ бусад холбогдох агентлаг, ашигт малтмалын хуулийн хэрэгжилт	Ж.Отгонбаяр Ж.Гомбожав Ц.Өөлд С.Гүндэнбал /ТГ/	Тодорхойгүй	Тодорхойгүй	
6.	1999.12.09-ны №12 тогтоол	БОЯ бусад холбогдох байгууллага хүмүүс, Шонхор шувууг гадаадад экспортолж байгаа үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх	Батж.Батбаяр Ё.Гэрэлчулуун С.Оюун Ц.Банзрагч Л.Дүгэржав /ХААЯ- ны газрын орлогч/ Чилхаажав	Байнгын хорооны хурлаар ажлын хэсгийн дүнг хэлэлцсэн.	Байнгын хорооны 07 тоот тогтоол гарсан.	

\* \* \*

/2000 - 2008 он/

Д/д	Ажлын хэсэг байгуулсан шийдвэр, огноо • Ямар асуудлаар шалгалт хийсэн	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /УИХ-ын гишүүд, бусад албан хаагч/	Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал	Гаргасан шийдвэр	Тайлбар
1.	2000.08.09-ны №03 тогтоол • Улаанбаатар хотын хэмжээнд Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг үргэлжлүүлэн шалгах шалгалтын хэсэг	<b>Ахлагч:</b> Ш.Гунгаадорж БХ-ны дарга <b>Гишүүд:</b> Ц.Шийрэдвамба О.Нигамет Ч.Раднаа Л.Цэрэнжав Г.Нямдаваа	2000 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар <u>Нийслэлийн ногоон бүс дэхь газар олголт, ашиглалтын өнөөгийн байдал, газрын тухай хуулийн хэрэгжилтийн талаархи</u> Нийслэлийн Засаг дарга М.Энхболдын мэдээллийг сонссон.	<b>Нийслэлийн нутаг дэвсгэрт, газрын харилцааг боловсронгүй болгох талаар авах зарим арга хэмжээний тухай</b> Байнгын хорооны 2000 оны 09 дүгээр тоот тогтоол гарсан. /2000.12.12/	Удирдамжтай Хугацаа: 2008.08.07-09.15
